



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд;

1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах дэд хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны хэрэгжилттэй танилцан санал дүгнэлт өгөх;
2. Сумдын ЭЭС-ийн бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг орон нутгийн түвшинд хамгийн оновчтой байдлаар шийдвэрлэх;

Аймгийн засаг дарга, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст;

1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах дэд хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ИТХ-д танилцуулах;
2. Сумдын ЭЭС-ийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг судалж орон нутгийн хувьд хамгийн оновчтой бүтэц, зохион байгуулалтын гарц, шийдлийг олж, шийдвэрлүүлэх;
3. Эрүүл мэндийн бодлого зохицуулалт, хяналтын чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах;
4. Аймгийн эм зүйн салбарын хэмжээнд дутагдалтай байгаа эм зүйч, эм найруулагчийн орон тоог нөхөн бүрдүүлэх чиглэлээр орон нутгийн удирдлага, их дээд сургууль болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах;
5. Хууль, журам, стандартын шаардлага хангасан эмийн санд тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах эсэх асуудлыг шийдвэрлэж байх;

Аймгийн Эрүүл мэндийн газарт;

1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах дэд хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны хэрэгжилтийн явцад хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, аймгийн Засаг даргын зөвлөлийн болон аймгийн ИТХ-д хуралд танилцуулах;
2. Аймаг сумын эрүүл мэндийн байгууллагуудад эмийн гаж нөлөөг бүртгүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, эмийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, мэдээллийг эм, эмнэлгийн мэргэжилтэн, иргэдийн дунд тогтмол зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллах;

3. Нийтийн үйлчилгээтэй 24 эмийн сангийн эрхлэгч нар эм зүйн албаны менежментээр мэргэшүүлэх нэгдсэн зохион байгуулалттайгаар зохион байгуулах;
4. Сумдын ЭМТ-үүд болон ЭЭЗХ-ны эмийн хэрэглээний талаарх мэдээлэл болон ажлын тайлан, мэдээг нэгтгэн ЭМХТ-д хүргүүлэн, дүн шинжилгээ хийж, ЭЭЗХ-г арга зүй удирдлагаар хангаж ажиллах;

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт;

1. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжигдэх хөнгөлөлттэй эмийн цахим жорын бичилтийг эмч нараар тогтмол бичүүлж хэвшүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах;

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Д.ИХБАЯР

АУДИТОР

Д.ДОЛЖИНСҮРЭН

АУДИТОР

Ж.УГТАХБАЯР

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.НАРАНЦАЦРАЛ